



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/335

Эрдэнэт

Төрийн архивыг шинэ байранд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Архивын тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Ээлжит IV хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжлүүлэх үндсэн чиглэлийн 9.2, 10.1 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн архивыг 2017 оны 06 дугаар сарын 07 ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд шинэ байранд нүүлгэн шилжүүлэхийг Архивын тасаг / н Мөнхбаяр/-т даалгасугай.

2. Нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах комиссыг I, нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө, хуваарийг II, шаардагдах зардлыг III хавсралтаар тус тус баталсугай.

2. Архивын сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэхэд ажилд хүн хүч, техник хэрэгсэл оролцуулахыг Цэргийн штаб /хурандаа н.Батсуурь/ Хууль эрх зүйн хэлтэс / н.Ганзориг/ Хот тохижуулах газар /н.Оюунбаяр/- т тус тус үүрэг болгосугай .

3. Нүүлгэх ажилд зарцуулагдах зардал 4245000 /Дөрвөн сая хоёр зуун дөчин таван мянга / төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

4. Нүүлгэлтийн ажилд зарцуулагдах зардал төсвийг батлагдсан төсөвт багтаан, архивын баримт материалыг гэмтэж устгахаас хамгаалж, аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр нүүлгэлтийг зохион байгуулж, гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавьж ажиллахыг Архивын тасаг / н.Мөнхбаяр/-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



D:(Zahiramj) A-4 doc

0200601517


 Аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар
 сарын 16-ны өдрийн 135 дугаар
 захирамжийн 3 дугаар хавсралт

ТӨРИЙН АРХИВЫГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ		Нийт үнэ
1	Баримт зөөвөрлөх хайрцаг	ширхэг	500	500		250000
2	Архивын зориулалтын шат	ширхэг	1	120000		120000
3	Ажлын халад	ширхэг	10	15000		150000
4	Маск	ширхэг	50	1000		50000
5	Бээлий /алган талдаа резинтэй/	ширхэг	30	2000		60000
6	Скоч/том/	ширхэг	50	7000		350000
7	Стекер /олон өнгөтэй/	боодол	10	6000		60000
8	Маркер /хар,хөх/	ширхэг	25	1000		25000
9	Зөөврийн тэргэнцэр /төмөр/	ширхэг	1	95000		95000
10	Үдэгч машин	ширхэг	1	145000		145000
11	Нягтруулсан шүүгээг нүүлгэх зардал /буулгах, угсрах/	ширхэг	32	40000		1280000
Шатахуун, хоолны үнэ						
	Материалын нэр	Ажиллах хоногийн тоо	Нийт тоо	Нэг бүрийн үнэ		Нийт үнэ
12	Тээврийн зардал	14 хоног	40 удаа	1750	5 км	300000
13	Тээврийн зардал/жижиг машин/	14 хоног	40 удаа	1750	5 км	100000
14	Хоолны зардал	14 хоног	18 хүн	5000		1260000
Нийт						4245000